

Мэргэжлийн болон дээд боловсролын төсөв, санхүүгийн бодлого, төлөвлөлт, эдийн засгийн шинжилгээ хариуцсан шинжээч, Баясгалан
Чаминчулуун

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Боловсролын салбарын төсөв, санхүү, эдийн засгийн төлөвлөлтийг сайжруулах							
1	Боловсролын салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын байгууллагуудад 2024 оны батлагдсан төсвийн санхүүжилтийн сар улирлын хуваарь болон төсөвт баримтлах чиглэлийг боловсруулан хүргүүлнэ.	Хуваарь болон баримтлах чиглэл	2,576.5 тэрбум төгрөг	Хуваарь болон баримтлах чиглэлийг боловсруулж, баталгаажуулан хүргүүлж, хэрэгжилтийг хангахад удирдлага, мэргэжлийн арга зүйгээр ханган, хяналт тавьж бүрэн хэрэгжүүлсэн байна	Салбарын 2024 оны батлагдсан төсвийн хүрээнд гүйцэтгэл, үр дүнгийн санхүүжилт, хувьсах зардлын хэмжээ шинэчлэн батлах тухай Засгийн газрын 39, 53 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг хангах, Засгийн газраас үндсэн цалин, орон нутгийн нэмэгдэл цалин, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж, олон улсын нэмэлт хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, төсвийн тодотголтой холбоотой хэрэгжүүлэх чиглэлийг төсвийн төвлөрүүлэн захирагч буюу Боловсролын ерөнхий газар түүний харъяа шууд захирагч нарт Боловсролын сайдын болон газрын даргын 5	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					удаагийн албан бичгээр хүргүүлж ажилласан. Хавсралт: 5 файл		
2	Боловсролын салбарын 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орох тохиолдолд шаардлагатай тооцоо судалгааг боловсруулна.	Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орох тохиолдолд шаардлагатай тооцоо, саналыг холбогдох газарт хүргүүлж, нэгтгэлд тусгуулсан байна.	-	Батлагдсан төсөвт тодотгол хийгдэх тохиолдолд тооцоог боловсруулж хүргүүлсэн байна.	Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн үр дүнгээс шалтгаалан Засгийн газрын бүтцийн тухай хууль, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль, Засгийн газрын тухай хуулиудад тус тус өөрчлөлт орж, төсвийн ерөнхийлөн захирагч болон засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудал, хариуцах салбарын чиг үүрэгт нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотойгоор 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт хийх зайлшгүй шаардлага үүссэн. Тус нөхцөл байдалтай холбогдуулан шинжлэх ухааны салбарын чиг үүргийг хэрэгжүүлэх 31 байгууллагын 2024 оны батлагдсан төсвийг Монгол Улсын тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад шилжүүлэх түүнтэй холбоотой тооцоо судалгааг Сангийн сайд, Монгол улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргад хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулинд хориг тавьсантай холбоотойгоор Боловсролын сайдын багцын	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					2025 оны төсөвт хийгдэх нэмэлт өөрчлөлтийн саналыг Сангийн яаманд хүргүүлж ажилласан. Хавсралт: 3 файл		
1.2. Гүйцэтгэлд суурилсан төсөв, түүний төлөвлөлтийн чиглэлээр							
3	Боловсролын салбарын 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар боловсруулж, эрх бүхий байгууллагад саналыг хүргүүлж хамтран ажиллана.	Төсвийн тухай хуулийн 8.3.1 дэх заалтын дагуу хугацаанд нь хүргүүлнэ.	Салбарын 2024 оны батлагдсан төсөв.	-	Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх, дэлхий нийтийн хөгжлийн түгээмэл хандлагыг өөрийн орны онцлогт тохируулан тусгасан, хүний хөгжлийг хангах, эдийн засаг, нийгэм, засаглалын хөгжлийг ахисан түвшинд хүргэхэд чиглэсэн урт хугацааны зорилго, зорилт, хүрэх үр дүн, үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор Төсвийн тухай хууль, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, боловсролын багц хуулийн хэрэгжилтийг хангах боловсролын шинэ сэргэлтийн хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны салбарын 2025 оны төсвийн хязгаар, 2026-2027 оны төсвийн төсөөллийг боловсрууллаа. Боловсрол, шинжлэх ухааны салбарт сүүлийн 4 жилийн хугацаанд гүйцэтгэл, үр дүнд чиглэсэн төсвийн шинэчлэлийн хүрээнд дараах чиглэлүүдийг баримталсан. Үүнд: -	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					Ерөнхий боловсролын сургуулийг хагас бие даасан тогтолцоонд шилжүүлэх; - Нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын бүрэлдэхүүн, хэмжээг шинээр тооцож, санхүүжилтийн аргачлалыг шинэчлэх; - Сургуулийн бүтэц, хэв шинжийн оновчтой хувилбарыг тогтоох; - Сургалтын чанар, гүйцэтгэлд суурилсан багшийн цалин, урамшууллыг олгох. - Боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлэх хүрээнд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, санхүүгийн түрээсийн хэлбэрийг боловсролын салбарт хэрэгжүүлж эхэлсэн. Салбарын 2025 оны төсвийн хязгаарын нийт саналыг Монгол улсын 2025 оны ТХМ-д тусгагдсан ДНБ-ний хэмжээгээр тооцоолон ДНБ-ний 8 хувь буюу 7,408,002.7 сая төгрөг байхаар тооцож, үүнээс урсгал зардалд 4,880,802.0 сая төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2,598,929.9 сая төгрөг байхаар тус тус тооцож хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан. Хавсралт: 2 файл		
4	Боловсролын салбарын 2025 оны төсвийн төсөл,	Төсвийн тухай хуулийн 8.4.3 дахь заалтын	2024 оны төсвийн хязгаарын	Боловсрол, шинжлэх ухааны төсвийн	Багцын 2025 оны төсвийн төслийн 6,242.9 тэрбум төгрөгийн 4,231.2 тэрбум төгрөг	6-р сар, 7-р сар, 8-р сар,	Өөрийн үнэлгээ: 100%

	2026, 2027 оны төсвийн төсөөллийг боловсруулна.	дагуу хугацаанд нь хүргүүлнэ.	төсөлд Боловсрол, шинжлэх ухааны салбарын саналыг хүргүүлсэн байна.	ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн төсөл, 2025, 2026 оны төсвийн төсөөллийг боловсруулан УИХ, Сангийн яаманд хуульд заасан хугацаанд хүргүүлж, батлуулсан байна.	буюу 68 хувь нь боловсролын салбарын 2336 сургалтын байгууллагаар дамжуулан 1,140,999 хүүхдэд боловсролын үйлчилгээг хүргэх, нэг хүүхдэд ногдох өртөгт суурилсан хувьсах зардлаар дамжуулан гүйцэтгэл, үр дүнгийн санхүүжилтийг олгохоор төлөвлөсөн. Нийт төсвийн 32 хувь буюу 1,996.1 тэрбум төгрөг нь боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, хуулийн хэрэгжилтийг хангах, бодлого хэрэгжүүлэх, салбарын байгууллагуудын барилга байгууламжийг шинэчлэх, өргөтгөх, их засвар хийх болон тавилга, тоног төхөөрөмжөөр хангах зэрэг хөрөнгө оруулалтын зардалд зарцуулагдах юм. Монгол Улсын төсвийн хүрээний мэдэгдэлд дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг 8.0 хувиар тооцсон бөгөөд Боловсролын сайдын багцын 2025 оны төсвийн төсөл нь хязгаараас 58.7 хувиар давсан өсөлттэй байхаар байна. Мөн тус хуулийн дагуу тооцсоноор харьцуулахад Боловсролын салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөв нь улсын төсвийн нийт зарлагын 17 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 8 хувийг тус тус эзлэхээр байна. Салбарын 2025 оны төсвийн төслийн	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	---	-------------------------------	---	---	--	---------------------------------------	--

					саналыг Төсвийн тухай хуулийн 8.4.3-т заасны дагуу Улсын Их Хурлын дарга, Үндэсний аудитын газар, Сангийн яаманд тус тус хүргүүлж ажилласан. Хавсралт: 6 файл		
3.3. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж тайлагнах							
5	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг тайлагнах.	Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн тоо	2023 оны биелэлтийн хувь	Холбогдох заалтын хэрэгжилт хангагдсан байна.	Энэ арга хэмжээний хүрээнд Боловсролын яамны Санхүүгийн хэлтэст хэрэгжүүлэх арга хэмжээ тусгагдаагүй болно.	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
6	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2023 оны тайлан	Хугацаанд нь тайлагнасан байна. Хэрэгжилт хангагдсан байна.	Засгийн газрын 17 тогтоолын хүрээнд 28 хэрэгжилт, Ерөнхий сайдын 2 захирамжийн хүрээнд 2 хэрэгжилт, Засгийн газрын хуралдааны 11 тэмдэглэлийн 17 биелэлтийг, Засгийн газрын албан 1 даалгаварын хүрээнд 1 хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж, тайланг хуулийн хугацаанд тайлагнасан байна.	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа

							гүйцэтгэсэн байдал: 100%
7	Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнах.	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2022 оны тайлан	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Энэ арга хэмжээний хүрээнд Боловсролын яамны Санхүүгийн хэлтэст хэрэгжүүлэх арга хэмжээ тусгагдаагүй болно.	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
8	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2023 оны тайлан	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Энэ арга хэмжээний хүрээнд Боловсролын яамны Санхүүгийн хэлтэст хэрэгжүүлэх арга хэмжээ тусгагдаагүй болно.	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
3.4. Боловсролын салбарын эдийн засгийн төлөвлөлтийг сайжруулах							
9	Гүйцэтгэл, үр дүнд суурилсан	Эрх зүйн орчны шинэчлэлийг	-	Гүйцэтгэлд суурилсан	Боловсролын салбарын 2023 оны төсвийн гүйцэтгэлийн	6-р сар, 7-р сар,	Өөрийн

	төсөвлөлт, санхүүжилтийн эрх зүйн өөрчлөлтийг түгээн дэлгэрүүлэх, хэрэгжилт, тайлагналтад, мониторинг, хяналт шинжилгээ хийх үр дүнтэй тогтолцоог бий болгох чиглэлээр санал боловсруулж, шийдвэрлүүлнэ.	түгээн дэлгэрүүлж, үр дүнд мониторинг, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийгдсэн байна.		санхүүжилтийн тогтоолцоо, түүний үр дүнд мониторинг, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.	тайланд дүн шинжилгээ хийж, дүгнэлт боловсруулан цаашид анхаарах асуудал, зарчмын талаар харьяа байгууллагын төсвийн мэргэжилтнүүдтэй хамтарсан цахим хэлэлцүүлгийг зохион байгуулна. Үйл ажиллагааны хэрэгжилт 2,331.7 тэрбум төгрөг Хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. Боловсролын салбарын төсвийн гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог төгөлдөржүүлэх ажлын хүрээнд шинэчлэн батлагдсан хувьсах зардлаар санхүүжүүлэх журам, түүнийг хэрэгжүүлэх зааврыг таниулах, нэгдсэн ойлголт өгөх сургалт, хэлэлцүүлгийг 2024 оны 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс 03 дугаар сарын 11-ны өдрүүдэд зохион байгуулж ажилласан. Хэлэлцүүлэг арга хэмжээнд танхимаар 96 хүн хамрагдсан ба Фэйс буук шууд дамжуулалт 28 мянган хүн, teams 292 хүн оролцлоо. Хэлэлцүүлгийн үеэр Боловсролын салбарын хувьсах зардлын санхүүжилтээр сургалтын байгууллагуудад олгогдсон зардлаар худалдан авсан тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн, боловсролын салбарын их өгөгдлийн системийн танилцуулгыг үзүүлэн хэлбэрээр үзэсгэлэн	8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	---	--	---	--	--	---

					гаргалаа. Үзэсгэлэнд нийслэлийн 9, 37-р цэцэрлэг, Нийслэлийн боловсролын газар оролцож, хэрэглэгдэхүүнээ танилцууллаа. Мөн Засгийн газрын 39 болон 53 дугаар тогтоолоор хувьсах зардлын хэмжээ, түүний бүрэлдэхүүнийг үнийн өсөлт болон цалингийн өсөлтийн нөлөөллийг тусгаж шинэчлэн батлуулсан. Тус тогтоолуудтай холбоотойгоор хувьсах зардлын бүрэлдэхүүнийг зарцуулах зааврыг шинэчлэн боловсруулж боловсролын удирдлагын байгууллагуудын төсөв санхүүгийн ажилтнуудыг хамруулсан хэлэлцүүлгийг 2024 оны 10 дугаар сарын 17-19 өдрүүдэд зохион байгуулсан. Хавсралт: 2 файл		
10	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын менежментийг сайжруулах бодлого, чиглэлийн хүрээнд захиргаа, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн ажилтнуудын төсөв, санхүү, хөрөнгийн менежментийн	Сургалтын байгууллагын захиргаа, санхүү, удирдах ажилтнуудад төсөв, санхүү, хөрөнгийн менежментийн чадавхийг сайжруулах сургалтын модуль боловсруулсан байна. Модуль сургалтад	-	Батлагдсан модуль сургалтад 500-аас доошгүй ажилтнуудыг хамруулсан байна.	Боловсролын салбарын 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд дүн шинжилгээ хийж, дүгнэлт боловсруулан цаашид анхаарах асуудал, зарчмын талаар харьяа байгууллагын төсвийн мэргэжилтнүүдтэй хамтарсан цахим хэлэлцүүлгийг зохион байгуулна. Үйл ажиллагааны хэрэгжилт 2,331.7 тэрбум төгрөг Хэлэлцүүлэг зохион байгуулсан байна Боловсролын салбарын төсвийн гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

	чадавхыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	хамрагдсан ажилтнуудын тоо			тогтолцоог төгөлдөржүүлэх ажлын хүрээнд шинэчлэн батлагдсан хувьсах зардлаар санхүүжүүлэх журам, түүнийг хэрэгжүүлэх зааврыг таниулах, нэгдсэн ойлголт өгөх сургалт, хэлэлцүүлгийг 2024 оны 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс 03 дугаар сарын 11-ны өдрүүдэд зохион байгуулж ажилласан. Хэлэлцүүлэг арга хэмжээнд танхимаар 96 хүн хамрагдсан ба Фэйс буук шууд дамжуулалт 28 мянган хүн, teams 292 хүн оролцлоо. Хэлэлцүүлгийн үеэр Боловсролын салбарын хувьсах зардлын санхүүжилтээр сургалтын байгууллагуудад олгогдсон зардлаар худалдан авсан тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн, боловсролын салбарын их өгөгдлийн системийн танилцуулгыг үзүүлэн хэлбэрээр үзэсгэлэн гаргалаа. Үзэсгэлэнд нийслэлийн 9, 37-р цэцэрлэг, Нийслэлийн боловсролын газар оролцож, хэрэглэгдэхүүнээ танилцууллаа. Мөн Засгийн газрын 39 болон 53 дугаар тогтоолоор хувьсах зардлын хэмжээ, түүний бүрэлдэхүүнийг үнийн өсөлт болон цалингийн өсөлтийн нөлөөллийг тусгаж шинэчлэн батлуулсан. Тус тогтоолуудтай холбоотойгоор хувьсах зардлын		
--	--	-----------------------------------	--	--	--	--	--

					бүрэлдэхүүнийг зарцуулах зааврыг шинэчлэн боловсруулж боловсролын удирдлагын байгууллагуудын төсөв санхүүгийн ажилтнуудыг хамруулсан хэлэлцүүлгийг 2024 оны 10 дугаар сарын 17-19 өдрүүдэд зохион байгуулсан. Тус сургалт хэлэлцүүлэгтэй холбоотойгоор орон нутгийн түвшний төсөв санхүүгийн ажилтнуудыг хамруулсан сургалтыг зохион байгуулсан.		
11	Боловсролын салбарын ажилтнуудын орон тоо бүтэц, албан тушаалын ангилал, зэрэглэл болон цалин хөлсний өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, цалин хөлсний тогтолцоог сайжруулах чиглэлээр санал боловсруулна.	Одоогийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, олон улсын сайн жишгийг харгалзан үр дүнд суурилсан цалин хөлсний тогтолцоог бий болгох санал боловсруулж, хэлэлцүүлж, бодлого чиглэлийг тодорхойлсон байна.	-	Судалгааны үр дүн, холбогдох саналыг олон талын оролцоог ханган үе шаттай хэлэлцүүлж, салбарын цалин хөлсний талаар баримтлах бодлого, чиглэлийг боловсруулж, баталгаажуулсан байна.	Монгол Улсын Засгийн газраас цалин хөлсний түвшинг бодитой тогтоох, цалин хөлсийг бүтээмж болон амьжиргааны өртгийн өөрчлөлтэй уялдуулан аажим, тасралтгүй нэмэгдүүлэх, төрийн болон хувийн хэвшлийн цалин хөлсний түвшинг ойролцоо байлгах, цалин хөлсний зохицуулалтад нийгмийн зөвшилцийн механизм, хамтын гэрээний үндсэн дээр үе шаттайгаар нэмэгдүүлж ирсэн. Үүний дүнд боловсролын салбарын цалингийн өсөлт сүүлийн 12 жилийн байдлаар 169.1 хувийн өсөлттэй, инфляцийн өсөлтөөс давсан харагдаж байна. Боловсролын багц хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хот, хөдөөгийн боловсролын ялгааг арилгах, боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, сургалтын орчинг сайжруулах,	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					багшийн цалинг ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээнд суурилан санхүүжүүлэх, олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэн Монгол Улсын 2024 оны төсөвт багтаан өөрчлөлтүүдийг тусган энэхүү Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын 2024 оны 39, 53 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг ханган ажилллаж байна. 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс Засгийн газрын шийдвэрээр төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчийн үндсэн цалингийн доод хэмжээг 20 хувиар, бусад төрийн албан хаагчийн үндсэн цалингийн доод хэмжээг 10 хувиар тус тус нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд орон нутгийн нэмэгдлийг аймгийн төвийн суманд 20 хувь, бусад сумдад 40 хувиар тус тус тооцож олгох шийдвэрлэсэн байгаа бөгөөд салбарын хэмжээнд шаардагдах эх үүсвэрийн тооцоолол, төсвийн зохицуулалтаар хангаж ажилласан.		
3.5. Боловсролын салбарын төсвийн гүйцэтгэл, хэрэгжилтийн хангах							
12	Ялгаатай хэрэгцээнээс үл хамааран чанартай боловсрол эзэмших тэгш	Чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор хангахад	2023 оны төсвийн гүйцэтгэлээр	Батлагдсан төсвийг хэрэгжүүлж ажилласан байна.	2024 онд сургуулийн өмнөх боловсролын 323 суралцагчид 4,8 тэрбум төгрөг, ердийн цэцэрлэгт суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй 1342	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын

	боломжоор хангах үйл ажиллагаанд шаардлагатай төсвийн тооцоолол гаргаж, төсөв хуваарилсан байна.	зарцуулахаар батлагдсан төсвийн хэмжээ			суралцагчид 10.7 тэрбум төгрөг, Ерөнхий боловсролын тусгай хэрэгцээт сургалтын байгууллагын 1857 хүүхдэд 24.2 тэрбум төгрөг, ердийн ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй 4791 хүүхдэд 22.5 тэрбум төгрөг, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй 496 суралцагчид 3.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгож ажилласан. Хавсралт: 1 файл	11-р сар, 12-р сар	үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
3.6. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах							
13	Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.	Мэдээллийн тоо, хэрэгжилтийн хувь	2023 оны байршсан мэдээлэл	1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна. 2. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулсан байна.	Боловсролын сайдын багцын төсвийн гүйцэтгэлийн мэдээг 2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар нэгтгэж, шилэн дансны цахим системд оруулсан. Сар бүрий 8-ны дотор ТЕЗ-ийн 5 төрлийн мэдээллийг бэлтгэн shilendans.gov.mn системд тогмол , хугацаандаа мэдээллийг оруулсан байна. Шилэн дансны шинэчилсэн системд ТЦЗ-ийн ерөнхий нягтлан бодогчийг хэрэглэгчээр бүртгэсэн бөгөөд хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, батлагдсан төсөв, санхүүгийн тайлан, аудитын тайлан дүгнэлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ гэх	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					зэрэг мэдээллүүдийг өөрсдийн эрхээр хуулийн хугацаанд оруулахаар тохиргоо хийгдсэн. Хавсралт: 1 файл		
--	--	--	--	--	---	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтанд амжилттай оролцож гэрчилгээ авсан байна.	Сургалтад хамрагдсан байна.	-	АЗ гэрчилгээ авсан байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтанд амжилттай оролцож гэрчилгээ авсан. Хавсралт: 1 файл	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Мэргэжлийн болон дээд боловсролын төсөв, санхүүгийн бодлого, төлөвлөлт, эдийн засгийн шинжилгээ хариуцсан шинжээч, Баясгалан Чаминчулуун /...../ Огноо: